

Дэлхийн нуурын зөнд онцгойлон заасан долоон зарчим нуурыг тогтвортой ашиглах менежментэд хүрэх замыг зааж байна.

Зарчим 1: Хүн байгаль хоорондын зөвшилцсэн харьцаа
нуурын тогтвортой байдалд чухал ач
холбогдолтой

Зарчим 2: нуурыг тогтвортой ашиглах төлөвлөлт менежментийг Нуурын
ус хураах ай саваас эхлэх нь зүйтэй.

Зарчим 3: Нуурыг доройтлоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн урт
хугацааны идэвхтэй үйл ажиллагаа онцгой чухал

Зарчим 4: Нуурын менежментийн талаарх бодлого, шийдвэр нь
шинжилгээ судалгааны үр дүн, тодорхой мэдээлэл дээр
үндэслэгдсэн байх ёстой.

Зарчим 5: Нуур, түүний тогтвортой ашиглалтын менежмент нуурын
нөөцийг өрсөлдөн ашиглагчдийн дундах зөрчлийг
шийдвэрлэх, өнөө, ирээдүй үеийхэн болоод байгалийн
өөрийн хэрэгцээг харгалзсан байх шаардлагатай

Зарчим 6: Нуурын талаарх асуудлыг тодорхойлж шийдвэрлэхэд иргэд
ба бодлого хэрэгжүүлэгчид бодитой оролцох ёстой.

Зарчим 7: Шударга ёс, ил тод байдал дээр суурилсан сайн засаглал
нуурын тогтвортой хөгжилд чухал үүрэгтэй.

Дэлхийн нуурын зөн бол бүх нийтэд хандсан уриалга юм. Нуурыг тогтвортой ашиглах түлхүүр бол
хүн төрөлхтний усны хэрэгцээ энэ хэрэгцээг урт хугацаанд хангах байгалийн чадамж хоёрын
хоорондох тэнцлийг олоход оршиж байна. Энэ баримт бичиг нуурын оршин суугчид, шийдвэр
гаргагчид, болон бусад хүмүүст тухайн нэг
нуурын зөн буюу түүнийг тогтвортой ашиглах
арга замыг боловсруулахад нь туслах стратеги,
үйл ажиллагааны олон хувилбарыг санал
болгоно. Бид нуурыг тогтвортой, ухамсартай
ашиглаж чадах аваас амьдралын эх булаг
болсон цэнгэг уснаас хамарагч хүн болоод
байгалийн бүлгэмдлүүдийн хэрэгцээг хангах
боловжыг хараахан алдаагүй байгаа юм.




Олон Улсын Нуурын Орчны Хорооны Сан
(ОУНОХС)
1091 Oroshimo-cho Kusatsu, Shiga 525-0001,
JAPAN
www.ilec.or.jp e-mail:info@ilec.or.jp
Утас: +(81-77) 568-4567
Факс: +(81-77) 568-4568

Орчуулсан: Н.Сонинхишиг
Хөвсгөл-Бива нуурын нөхөрлөлийн нийгэмлэг дэмжив

ДЭЛХИЙН НУУРЫН ЗӨН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УРИАЛГА



Дэлхийн Нуурын Зөнгийн Хороо



Дэлхийн нуурын зөн: Urialga

Хэмжээ хягаартай дэлхий өртөнцөд зохицож, цэвэр ус зэрэг онцгой нөөцийн хомсдлыг хүлээн зөвшөөрч чадахуйц иргэншилийг хөгжүүлэх хүндхэн асуудал шинэ зуунд хүн төрөлхтний өмнө тулгарч байна. Нуур бол хамгийн хялбар аргаар ашиглаж болох цэнгэг усны анхдагч нөөц тул оршин байгаа байгалийн үндэс сууриа ганхуулж, хоослолгүйгээр тогтвортой оршин тогтоно нийгэм рүү шилжих энэ цаг үед онцгой анхаарлын төөд байх болно. Эдүгээ олон нуур аюул сүйрэлд нэгэнт өртөөд байгаа билээ. Дэлхийн нуурын зөн нь өсөн нэмэгдэж байгаа хямралыг багасгах, нуурыг зохистой ашиглах менежмент боловсруулахад туслах зарчмуудыг тодорхойлох, нуурыг урт хугацаанд тэнцвэртэй байлгаж, хүний нийгмийн оршин тогтнолд хэрэгтэй цэнгэг ус, эдийн засгийн хөгжил дэвшилийн цогц байдал, амьдралыг тэтгэгч экосистемийг хэвээр хадгалахад шаардлагатай үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр хангах зорилготой.

Дэлхийн гадаргууд шингэн байдлаар оршдог цэнгэг усны 90 гаруй хувийг агуулж буй нууруудад нүүрлээд байгаа асуудал үнэхээр тулгамдсан, нэн даруй шийдвэрлэх асуудал гэдгийг томёолох нь амаргүй хэрэг. Дэлхийн хэмжээний ач холбогдолтой олон нуур хямралд орж, нуурын ус, түүнд амьдрагч организмуудын тоо болон чанар, нуураас ундаалдаг оршин суугчдын ахуйн хэрэгцээний усан хангамжид үнэхээр олон асуудал тулгарч байна. Усны цутгал хэт нэмэгдэх юмуу багассанаас зарим нуур сүйдэж, зарим нь нуур орчмын газар нутаг дах хүний зохисгүй үйл ажиллагаанаас үүдэн дорийтож байна. Сүүлийн хэдэн арван жилд хүчлийн бороо, уур амьсгалын өөрчлөлт зэрэг нуурын сав газраас бус, гаднаас үүдэлтэй асуудлууд

нэгэнт доройтсон экосистемд илүү их хүндрэл учруулах боллоо.

Хямрал өсөн нэмэгдсээр атал нуурын эрүүл мэнд ба хүн амын усны хэрэгцээг урт хуга-цаанд ханганд зохицуулахад шаардагдах сайн боловсрогдсон, нэгдсэн төлөвлөгөө ихэнх нуурын хувьд өнөө хир байхгүй байна.

Нуурын менежмент, хамгааллын талаарх өнөөгийн ажил хэрэг арга ажиллагааны хувьд хэт нарийссан, хэсэг бусаг байгаа учраас амжилтанд хүрэхгүй байгаа юм.

Дэлхийн нуурын зөн нуурын менежментийн талаар бидэнд тулгараад байгаа энэхүү түвэгтэй асуудлыг шийдвэрлэхэд дэлгэрэнгүй зөвлөмж санал болгож үйл ажиллагааны удирдамжаар хангана. Энэхүү баримт бичиг янз бүрийн байгууллага, хүмүүст тустай байж болох ч нуурын



сав газарт амьдрагч бүх иргэдийн үйл ажиллагааг дэмжих эхний болоод эцсийн зорилготой.

Одоогоор Азийн өмнөд-төв хэсэгт орших Арал тэнгисийг эс тооцвол ноцтой доройтолд орсон нуур харьцангуй цөөн байна. Цутгал голуудыг боосноос Арал тэнгис үндсэндээ ширгэн устаж байгаа юм. Бодлоглоос хамгаалах, тогтвортой ашиглах цогц, нэгдсэн арга ажиллагаа байхгүйгээс үүдэн олон нуур, түүнээс хамааралтай амьдардаг хүмүүс ойрын ирээдүйд хяналтаас алдарсан хэцүү асуудалтай эн тэнцүү тулгарч болзошгүй юм.

Нөгөөтэйгүүр нуур байгалийн гайхалтай гоёмсог тогтоц, биологийн нарийн нийлмэл цогц болохын хувьд хүний нийгмийн соёл, үзэгслэnt газар нутгийн чухал ай савд тооцогддог билээ.

Дэлхийн нуурын зөн дэлхийн нуурын ажил хэрэгч менежментийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхэд туслах зарчмуудыг санал болгож байна. Энэ зарчмууд Дэлхийн усны зөнд нэгэнт тусгагдсан зарчмуудыг өргөжүүлж, ялангуяа нуур, түүний давтагдашгүй шинж чанар, ашиглалт, тэдгээрт тулгарсан асуудалд онцгой анхаарал хандуулсан. Эдгээр асуудлыг шийдвэрлэхэд туслах боломжийн стратегийг тусгасан бөгөөд орон нутгийн болоод үндэстний аль ч



түвшинд ажиллаж байгаа хувь хүн, байгууллага удаан хугацаанд мөрдөн ажиллах боломжтой юм.

Үндсэн Зарчмуудыг хэрэгжүүлэх замаар энэ үйл хэргийг эхлэх нь зүйтэй. Хүмүүс болон Засгийн газрын хувьд байгаль орчны ноцтой, нөхөн сэргээгдэшгүй ялангуяа нуурт эмзэг тусахуйц сүйрэлд хүргэж болзошгүй аливаа үйл ажиллагааг хойшлуулах, бодлого боловсруулахдаа шинжлэх ухааны бүрэн үндэслэлтэй ханддаг байхад онцгой ач холбогдол өгөх хэрэгтэй. Цэнгэг усны нөөцийг зохицуулах Дублины зарчмуудад тусгагдсанчлан энэ үйл хэрэгт олон нийтийн нэн ялангуяа эмэгтэйчүүдийн үүрэг оролцоонд онцгой ач холбогдол өгч байна.

